Аудитыг Анализ старт аудит ХХК-ийн ахлах аудитор Ц.Саранцэцэг аудитор Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал Н.Энхтуяа, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын албаны аудитын менежер Я.Алтанцэцэг, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 75 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 27,998,778.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 279,987.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,437,417.0 мянган төгрөгөөр буюу 15.8 хувиар өссөн тул 32,436,195.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 324,361.9 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор байгууллага чиг үүргийн давхардал бүхий албан томилгоо хийгээгүй, төсвийн хөрөнгөөр архи, согтууруулах ундаа, бэлэг дурсгалын зүйл худалдан аваагүй бөгөөд эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглах эм, эмнэлгийн хэрэгсэл, үйл ажиллагааны бусад шаардлага бүхий материалыг “ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу нээлттэй тендер зарлан сонгон шалгаруулалтыг гүйцэтгэж худалдан авалт хийсэн байна.

Нэгдсэн судалгааны үр дүн:

- Удирдлагын зөвлөлийн хурлын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэл, ЭМТ-ийн даргын 2024 оны Б/599 дугаар тушаалаар унааны хөнгөлөлтийг 1.0 мянган төгрөг, хоолны хөнгөлөлтийг 24.0 мянган төгрөгөөр тогтоон олгож байсныг Удирдлагын зөвлөлийн хурлын 2025 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хурлын тэмдэглэл, ЭМТ-ийн даргын үүрэг гүйцэтгэгчийн 2025 оны Б/271 дугаар тушаалаар унааны хөнгөлөлтийг 2.0 мянган төгрөг, хоолны хөнгөлөлтийг 9.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоожээ.
- Батлагдсан орон тоо 538, гүйцэтгэлээр 456 орон тоогоор ажилласан. Орон тоо цомхотгоогүй.
- ӨМӨЗО-ны Олон Улсын Монгол Эмнэлгийн хороотой хамтарсан, Чанарын удирдлагын тогтолцооны, Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн, “Спирометр судлал" мэргэжил дээшлүүлэх, Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтны, нийт 6 сургалт, Эмч нарын өдрийг угтан "Эрдмийн чуулган 2025",Сувилагч, эх баригчдын өдрийг угтан "Эрдмийн чуулган 2025" гэсэн 2 чуулган зохион байгуулж, 11,957.6 мянган төгрөг зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 25 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий зарлагын 2,175,837.9 мянган төгрөгийн 100 гүйлгээ, орлогын 1,037,248.6 мянган төгрөгийн 2 гүйлгээ, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 118,105.3 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй, 10 мэдээллийг хугацааг хоцроож байршуулсан, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т “*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ*", 6.4.5-д "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*" гэж заасантай нийцээгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг аудитад хамруулж 14,066.2 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчил илрүүлж, 9 алдааг залруулах, зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар давтан үнэлж үзэхэд 9 алдааг залруулсан, 2 зөрчлийг арилгаагүй байсан тул жилийн эцсийн асуудлын бүртгэлд тусгалаа.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 61,598.2 мянган төгрөгийн 2 албан шаардлагын хэрэгжилт 50 хувь, 49,135.2 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх оны үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | | | | | |
| Албан шаардлага | 2 | 12,463.0 | 1 | 12,463.0 | 50.0 |
| Зөвлөмж | 4 | 49,135.2 | 4 | 49,135.2 | 100.0 |
| **Нийт дүн** | **2** | **61,598.2** | **2** | **61,598.2** | **50.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
**Дараа жилийн санхүүгийн тайлангийн аудитаар:**

-Харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулж, тооцоо нийлсэн акт үйлдсэн болович И-баримтын системд байгаа нэхэмжлэхийн дүн

санхүүгийн байдлын тайлан дахь өглөгийн дүнтэй таарахгүй байгааг анхаарах шаардлагатай.

-Авлага, өглөгийн харьцаанаас үзэхэд өглөг 2,436,598.2 мянган төгрөгөөр авлагаас давсан үзүүлэлтэй байгаа нь өр төлөхөд орлогын эх үүсвэр дутагдалтай болж, санхүүгийн хүндрэлтэй учирч болзошгүй байна.
-Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар батласан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг сайжруулахтай холбоотойгоор Сангийн яамны Finperform.mof.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах, дансны жишиг жагсаалтыг тус сайт дахь бүртгэлтэй тохируулах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,816.0 [1] илэрснээс аудитын явцад 20,816.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- НДАА-ны тогтоосон 20,816.0 мянган төгрөгийн актын төлбөрийг хүчингүй болгосон гэх боловч шийдвэр нь ирээгүй байхад өглөг бууруулж бүртгэсэн. Энэ нь УСНББОУС 1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д.”дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; 20.2.6-д”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”; гэж заасантай нийцэхгүй, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 208,079,9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,988.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 10,000.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 194,092.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 208,079,9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу шат хийлгэх төлбөрт 2025 онд 1,800.0 мянган төгрөг, НББББББ-ыг боловсруулах төлбөрт 2023 онд 2,188.8 мянган төгрөг, нийт 3,988.8 мянган төгрөг төлж, ажлыг гүйцэтгээгүй, биетээр хүлээн авсан нотлох баримтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж,

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйцэтгээгүй, биетээр хүлээн авсан нотлох баримтгүй зарцуулсан 3,988.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

1. НДШ, ХХОАТ-ын өр төлбөр оны эхний үлдэгдлээс 86.7 хувиар өсөж гүйцэтгэлээр олгосон санхүүжилтийг зөв удирдаагүй, ажилтнуудыг НД-ын сангаас авах тусламж үйлчилгээг эдлэх нөхцлөөр хангаж ажиллаагүй байна. ХХОАТ, НДШ-ийн өр төлбөрийг (3,578,839.1 мянган төгрөг) төсөвт төлж барагдуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн *"5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх*";Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн *27 дугаар зүйлийн 27.1-д "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1, 20.4-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.*" Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн *21.1-д "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө"* гэж заасантай нийцэхгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: *Шийдвэрлэсэн нь*: НДШ, ХХОАТ-ын өр төлбөрийг хуульд заасан хугацаанд улсын төсөвт төвлөрүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Ажлаас халагдсан 1 ажилтанд шүүхийн шийдвэрээр 10,000.0 мянган төгрөгийн нөхөн олговор олгож авлагаар бүртгээгүй, буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1."Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ." заалттай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шүүхийн шийдвэрээр олгосон нөхөн олговорыг авлагаар бүртгээгүй, шийдвэр гаргасан буруутай этгээдээр төлүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт-1: Элэгдлээрээ өртгөө нөхсөн (*2,366,318.4 мянган төгрөгийн)* анхны өртөгтэй 443 үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгуулаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын "*Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" журмын 7.1 "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон*

*элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ*” гэж заасантай нийцээгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Элэгдлээрээ өртгөө нөхсөн 443 үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах талаар саналыг боловсруулж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

2.Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт-2:

Ашиглалтын шаардлага хангахгүй 20,432.3 мянган төгрөгийн бараа материалыг зохих журмын дагуу шийдвэрлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... ажлыг зохион байгуулах, удирдах”, гэсэн заалттай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Ашиглалтын шаардлага хангахгүй бараа материалыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх зөвлөмж өгсөн.

3. ЭМДС-гаас нэхэмжилсэн авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЭМДС-гаас нэхэмжилсэн авлагаас эмчийн хасагдуулгаар 173,658.9 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.2-т "эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах", 13.1.4-д "даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх", 13.1-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* ЭМДС-гаас авах авлагаас хийгддэг хасагдуулга, түүний дотор эмчийн хасагдуулгыг өмнөх оноос 20-иос доошгүй хувиар бууруулж, орлогыг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| НДАА-ны тогтоосон 20,816.0 мянган төгрөгийн актын төлбөрийг хүчингүй болгосон гэх боловч шийдвэр нь ирээгүй байхад өглөг бууруулсан байна. | 1 | 20,816.0 | | | 1 | 20,816.0 | 1 | 20,816.0 | | | | |
| Дүн | 1 | 20,816.0 | | | 1 | 20,816.0 | 1 | 20,816.0 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шүүхийн шийдвэрээр ажлаас халагдсан 1 ажилтанд 10,000.0 мянган төгрөгийн нөхөн олговор олгосон ба авлагаар бүртгээгүй. | 1 | 10,000.0 | | | 1 | 10,000.0 | | | | | | |
| Элэгдлээ бүрэн нөхсөн, 2,366,318.4 мянган | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| төгрөгийн үндсэн хөрөнгө байгааг зохих журмын дагуу шийдвэрлүүлээгүй байна. | | | | | | | | | | | | |
| Ашиглалтын шаардлага хангахгүй 20,432.3 мянган төгрөгийн бараа материал байна. | 1 | 20,432.3 | | | | | 1 | 20,432.3 | | | | |
| Эмчийн хасагдуулга 173,658.9 мянган төгрөг байна. | 1 | 173,658.9 | | | | | 1 | 173,658.9 | | | | |
| Вест бюлдинг ХХКомпаниар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу шат хийлгэхээр 2025.2.13-нд гэрээ байгуулахгүйгээр 1,800.0 мянган төгрөг шилжүүлж, Урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэсэн бөгөөд ажил хийгдээгүй, төлбөрөө буцаан аваагүй, НББ-ийг захиалгаар хийлгэхээр 2023 онд 2,188.8мянган төгрөг шилжүүлээд хүлээн авсаныг нотлох баримт байхгүй байна. | 1 | 3,988.8 | 1 | 3,988.8 | | | | | | | | |
| Татварт 1,211,394.7 мян, Нийгмийн даатгалын 2,326,715.4 мянган төгрөгийн өртэй гарсан. | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |
| Дүн | 6 | 208,079.9 | 1 | 3,988.8 | 2 | 10,000.0 | 3 | 194,092.2 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий зарлагын 2,175,837.9 мянган төгрөгийн 100 гүйлгээ, орлогын 1,037,248.6 мянган төгрөгийн 2 гүйлгээ, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 118,105.3 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй, 10 мэдээллийг хугацааг хоцроож байршуулсан, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. | 1 | 3,331,191,8 | | | | | | | 1 | 1 | | |
| Дүн | 1 | 3,331,191,8 | | | | | | | 1 | 1 | | |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2026 оны 02 дугаар сарын 25 № 39/25025 443 Улаанбаатар хот

НТАГ-2026 / 049 / НА - СТА - ТШЗ

**Төлбөр барагдуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу шат хийлгэх төлбөрт 2025 онд 1,800,000.0 (Нэг сая найман зуун мянга) төгрөг, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах төлбөрт 2023 онд 2,188.800.0 (Хоёр сая нэг зуун наян найман мянга найман зуу) төгрөг, нийт 3,988,800.0 (Гурван сая есөн зуун наян найман мянга найман зуу) төгрөг төлсөн боловч ажлыг гүйцэтгээгүй, биетээр хүлээн авсан нотлох баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*", 20.2.6-д "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Ажил гүйцэтгээгүй, биетээр хүлээн авсан нотлох баримтгүй зарцуулсан 3,988.800.0 төгрөгийг Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Бямбасүрэн), Санхүү, бүртгэлийн албаны дарга (О.Тэгшдэлгэр) нараар төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү торгуулийн орлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110105

2.Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх аудитын газарт[1] ирүүлэхийг ажиллахыг Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Бямбасүрэн), Санхүү, бүртгэлийн албаны дарга (О.Тэгшдэлгэр) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Н.ЭНХТУЯА

--------------------------------

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 160/25025443 Улаанбаатар хот

НТАГ-2026/049/НА-СТА-ТШЗ

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын өр төлбөр оны эхний үлдэгдлээс 86.7 хувиар өсөж, гүйцэтгэлээр олгосон санхүүжилтийг зөв удирдаагүй, ажилтнуудыг нийгмийн даатгалын сангаас авах тусламж үйлчилгээг эдлэх нөхцлөөр хангаж ажиллаагүй байна. Хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг (3,578,839,137.37 төгрөг) төсөвт төлж барагдуулаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д "энэ хуулийн 15.1, 16.1.1, 17.1.2, 17.1.3-т тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.2.4-т заасан хувиар тооцон тухай бүр албан татвар ногдуулан, дараа сарын 15-ны өдрийн дотор;" Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн *21.1-д "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө"* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн..." заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийи хуульд заасан хугацаанд төсөвт төвлөрүүлээгүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Нийслэл дэх аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Бямбасүрэн), Санхүү, бүртгэлийн албаны дарга (О.Тэгшдэлгэр) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Н.ЭНХТУЯА

---

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090339

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 161/25025443 Улаанбаатар хот

НТАГ-2026/049/НА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансанд мэдээлбэл зохих 3,331,191,964.00 (*гурван тэрбум гурван зуун гучин нэгэн сая нэг зуун ерэн нэгэн мянга есөн зуун жаран дөрөв)* төгрөгийн мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ*", 6.4.5-д "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", 42 дугаар зүйлийн 42.1-д "*Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно*", 42.3-т "*Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2-д "*Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ.*" заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090341

1.Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй Санхүү, бүртгэлийн албаны дарга (О.Тэгщдэлгэр)-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах;

2.Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 31-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Бямбасүрэн)-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Н.ЭНХТУЯА

---------------------------------

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар